



## ШҮҮХИЙН АХМАДУУДЫН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

“Хүндэт тэмдэг”, түүний билэгдэл, загвар  
батлах, зардал шийдвэрлэх тухай

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.7, Шүүхийн ахмадуудын холбооны дүрмийн 7.6, 7.7, 7.8.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шүүхийн ахмадуудын холбоо”-ны “Хүндэт тэмдэг”, “Бэлгэдэл”-ийн загварыг хавсралтаар баталсугай.

2. “Хүндэт тэмдэг”-ийн зураглалыг зохиож, “Зоос гоёл”-ын үйлдвэрийн “Хас гоёл” ХХК-д захиалан бүтээлгэж, 20 ширхэг тэмдэг хийлгэхийг Холбооны дэд тэргүүн /Д.ТАЙВАНХҮҮ/-д даалгасугай.

3. “Хас гоёл” ХХК-ны нэхэмжлэхийг үндэслэн тэмдэгийн эх загвар зохион бүтээлгэсний зардалд 250.000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг, 20 ширхэг тэмдгийн зардалд 480.000 /дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг Холбооны данснаас тус тус зарлага болгохыг дэд тэргүүн /Д.ТАЙВАНХҮҮ/, нягтлан бодогч /Ц.ГАНДИЙМАА / нарт зөвшөөрсүгэй.

ТЭРГҮҮН



/Д.ГАНСҮХ/



*Холбооны удирдах зөвлөлийн хуралдааны 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батласан Монгол шүүхийн ахмадуудын холбооны хүндэт тэмдэгийн загвар*

### **“ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ийн загвар, бэлэгдэл**

1. “Шүүхийн ахмадуудын холбоо”-ны “Хүндэт тэмдэг” нь Монголын шүүх, шүүгчдийн түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийн илэрхийлэл болно.

2. “Хүндэт тэмдэг” нь ариун цагаан өнгийн бадамлянхуа цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэхийн бэлгэдэл болгон алтан тариагаар хөвөөлсөн хөх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх-цэнхэр дэвсгэртэй байна.

3. Тэмдгийн төв хэсэгт Монгол улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн “Алтан соёмбо”, шударга ёсны бэлгэдэл дэнсийг хослуулан дүрсэлсэн байна.

4. Сүлдний хүрээний магнай хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч “Чандмань эрдэнэ”, доод хэсэгт нь ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадагаар дээдлэн сүлжсэн байна.

5. “Хүндэт тэмдэг”-ийн хүрээний гаднах жижиг талстууд дээр ашид мандан бадрахын бэлгэдэл болгож үргэлж эрч хүчтэй, ялагдашгүй байхыг бэлгэдэж, таван улаан өнгийн шигтгээ суулгасан байна.



## ШҮҮХИЙН АХМАДУУДЫН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар . 1

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Шүүхийн ахмадуудын холбооны дүрмийн 7.6, 7.7, 7.8.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Шүүхийн ахмадуудын холбоо"-ны "Хүндэт тэмдэг" олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

ТЭРГҮҮН



/Д.ГАНСҮХ/

### Шүүхийн ахмадуудын холбооны "Хүндэт тэмдэг"-ээр шагнах журам.

1. "Шүүхийн ахмадуудын холбоо"-ны "Хүндэт тэмдэг" олгох журмыг Холбооны удирдах зөвлөлийн хуралдаанаас батлана.

2. Шүүхийн ахмадуудын холбооны "Хүндэт тэмдэг"-ийг шудрага ёсыг хангахад бодитой хувь нэмэр оруулсан, шүүх болон шүүхийн захиргаа, үйлчилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, Монголын шүүхийн ахмадуудын холбооны ажилд идэвхи зүтгэл гарган оролцсон шүүхийн ахмад шүүгч, ахмад ажилтан, иргэн, албан байгууллага хамт олонд Монголын шүүхийн ахмадуудын холбооны удирдах зөвлөлийн тогтоол /шийдвэр/-оор олгоно.

3. Шүүхийн ахмадуудын холбооны хүндэт тэмдэг үнэмлэх, мөнгөн урамшуулалтай байна. Мөнгөн урамшуулалын хэмжээ 50,000/тавин мянган/төгрөг байна.